

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2022 оны 01 сарын 04
өдрийн 5625 дугаарт бүртгэв.

Дундговь аймгийн
САЙХАН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 12 16

25

Малын тоо толгойд 2022 онд ногдуулах
албан татварын хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нэг малын тоо толгойд 2022 онд ногдуулах албан татварын хэмжээг дор дурьдсанаар тогтоосугай.

- 1.1. Тэмээ -1000 төгрөг
- 1.2. Адуу -1000 төгрөг
- 1.3. Үхэр -1000 төгрөг
- 1.4. Хонь – 200 төгрөг
- 1.5. Ямаа - 250 төгрөг

2. Малын тоо толгойн албан татварыг холбогдох баримт бичиг, шийдвэрт үндэслэн үнэн зөв, бодитой тогтоож төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга (С.Амарсанаа)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Цогхийморь)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.УНДРАЛ



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2022 оны 01 сарын 04 ны
өдөр хүлээн авсан.

2021 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 24

Онги

Малын тоо толгойн албан татварын
хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.1 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 2021 онд төвлөрүүлэх Малын тоо толгойн албан татварын хэмжээг малын төрөл, толгой тус бүрээр тэмээ 2000 төгрөг, адуу 2000 төгрөг, үхэр 2000 төгрөг, хонь 400 төгрөг, ямаа 500 төгрөг ногдуулахаар хэлэлцэн баталсан. 2020-2021 онд байгаль цаг агаарын гамшигт үзэгдэл удаа дараа тохиолдсоны улмаас өвөлжилт, хаваржилт ихэнх нутгаар хүндэрч мал ихээр хорогдож, малчид отор нүүдэлд их хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулж санхүүгийн хувьд хүндрэл үүссэн зэргийг харгалзан 2021 онд ногдуулсан малын тоо толгойн албан татварын хэмжээг 50 хувиар бууруулж тооцсугай.

2. Малын тоо толгойн албан татварыг холбогдох баримт бичиг, шийдвэрт үндэслэн үнэн зөв, бодитой тогтоож төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга (С.Амарсанаа)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Цогхийморь) –д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.УНДРАЛ

482120171